



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА НЯМ-ОСОРЫН  
УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: [info@cabinet.gov.mn](mailto:info@cabinet.gov.mn),

Цахим хуудас: [www.mongolia.gov.mn](http://www.mongolia.gov.mn)

2025.12.18 № 3Г-1/141

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын  
Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын  
хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж  
байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: [info@cabinet.gov.mn](mailto:info@cabinet.gov.mn),  
Цахим хуудас: [www.cabinet.gov.mn](http://www.cabinet.gov.mn)

2025.12.18 № НЭТ/3557  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай**

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын  
Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас Улсын  
Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт  
хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт 77 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА




С.БЯМБАЦОГТ

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“4.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,


Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025. 12. 17 № 1/2803

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**САНГИЙН САЙД  
Б.ЖАВХЛАН ТАНАА**

Монгол Улс болон Европын сэргээн босголт,  
хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр  
соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль  
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8  
дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн  
мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



**Б.ЭНХБАЯР**

А5 файл.2025  
151800043



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Энхтайваны өргөн чөлөө 7а,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,  
Цахим шуудан: info@mfa.gov.mn,  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2025.12.18 № 01/5995

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН  
ТАНАА

Танаас 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 01/10994 дугаартай албан бичгээр ирүүлсэн Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасны дагуу үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

115252482



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: [info@mof.gov.mn](mailto:info@mof.gov.mn),  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>


2025. 12. 17 № 01/10996

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар  
зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу “Зүрх  
судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн  
Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай  
хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн  
мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761002354

Огноо: 2025.12.02

**БАТЛАВ.  
САНГИЙН САЙД**



**Б.ЖАВХЛАН**

**БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН  
ТЭРГҮҮН ШАДАР  
САЙД БӨГӨӨД ЭДИЙН  
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН  
САЙД**



**Ж.ЭНХБАЯР**

**БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД**



**Ж.ЧИНБҮРЭН**

**БАТЛАВ.  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**



**Б.БАТЦЭЦЭГ**

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД**



**Б.ЭНХБАЯР**

**МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК  
ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл,  
шаардлага**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл, 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Төсөв болон Аюулгүй байдал, Гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 98 дугаар захирамжийг тус тус үндэслэн Монгол Улс

болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан.

Тус Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

**Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулсан “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

**Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн барилга угсралтын багц ажил болон магадалшгүй бусад ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэх боломжтой болно.

**Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон Улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах хүчингүй болгох хууль байхгүй болно.

## **ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

### **1.Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд тус зүйлд 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасан “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно.

### **2.Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:**

2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах харилцаа тул тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

### **3.Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Төслийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тус төслийн Зээлийн хэлэлцээг хийж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны, Улсын Их Хурлын Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хамтарсан хуралдааны санал, дүгнэлт болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 98 дугаар захирамжийг тус тус үндэслэн “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан.

### **4.Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:**

Уг хуулийн төсөлд тусгасан Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийн хүрээнд “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн худалдан авалт, барилга угсралтын багц ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэх бөгөөд Эрүүл мэндийн яам, Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Улсын гуравдугаар төв эмнэлгийн зүгээс холбоотой бусад судалгааг хийж ажилласан.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс болон Европын сэргээн босголт,  
хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг  
соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1.Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд тус зүйл 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасан “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно. /Төслийн танилцуулгыг хавсаргав/

**“Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн тухай**

**Нэг. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага**

Зүрх судасны шалтгаант нас баралт нь сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол Улсын иргэдийн нас баралтын тэргүүлэх (2024 онд 5789 нас баралт) шалтгаан болсоор байгаа бөгөөд тус шалтгаант нас баралтын 35% нь 45-65 насны буюу хөдөлмөрийн насны иргэд байна. Мөн иргэдийн дунд зүрх судасны өвчлөлийн эрсдэл, хүчин зүйлийн тархалт өндөр буюу хүн амын 75% нь зүрх судасны өвчлөлийн эрсдэлтэй байна.

Зүрх судасны өвчнөөр өвчилсөн хүмүүст Монгол Улсын хэмжээнд хийгдсэн нийт зүрхний мэс заслын 95%, судсан дотуурх оношилгоо, эмчилгээний 67%, хэм алдагдлын эмчилгээний 93%-ийг Улсын гуравдугаар төв эмнэлэгт дангаар гүйцэтгэсэн бөгөөд тус эмнэлгийн зүгээс 2024 оны байдлаар зүрхний нээлттэй нийт 425 мэс засал хийсний 120 нь хүүхдийн мэс засал байна.

Зүрх судасны үндэсний төв байгуулах хэрэгцээ, шаардлагын талаарх тандан судалгаагаар 2030 он гэхэд манай улсын зүрх судасны тусламж, үйлчилгээний шаардлага 2.6 дахин нэмэгдэхээр тооцоологдсон байна. Ялангуяа Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн дангаар, эсвэл давамгайлан үзүүлдэг зүрх судасны мэс засал 0.87 дахин, зүрх судсан дотуурх мэс засал 1.45 дахин, ахисан түвшний зүрх судасны оношилгоо, эмчилгээ 2.6 дахин тус тус нэмэгдэхээр байна.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн одоогийн барилга нь 1985 онд ашиглалтад орсон бөгөөд зүрх судасны тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд стандартыг өндөр түвшинд хангах шаардлагатай ахисан түвшний мэс засал буюу хүүхдийн хүнд хэлбэрийн хавсарсан гажгийн мэс засал, судсан дотуур зүрхний хавхалга суулгах мэс заслуудыг халдвар хамгааллын дэглэмийг нарийн мэргэжлийн, аюулгүй түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

**Хоёр. Төслийн санхүүжилтийн хэмжээ, нөхцөл, хамрах хүрээ**

Төсөл хэрэгжүүлэгч: Эрүүл мэндийн яам

Төсөл хэрэгжих хугацаа: 2025 он–2029 он /5 жил/

Төслийн санхүүжилт:

- Барилгын ажлын зардал: 34.9 сая ам доллар;
- Тоног төхөөрөмж, сургалт, барилгын хяналтын зардал: 22.5 сая евро.

“Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийг Европын сэргээн босголт, хөгжлийн банк /цаашид “ЕСБХБ” гэх/-аас олгох 34.9 сая ам.долларын зээлийн хөрөнгө болон Люксембургийн Их Гүнт Улсаас олгох 22.5 сая евро /~26.3 сая ам.доллар/-ийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

ЕСБХБ-аас санал болгож буй зээлийн хөрөнгө нь баталгаат овернайт санхүүжилтийн хувьсах хүү /SOFR/ дээр 1.6 хувийн нэмэгдэлтэй, 4 жил үндсэн

төлбөрөөс чөлөөлөгдөх, 18 жилийн хугацаатай бөгөөд хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж жилийн 0.5 хувьтай тэнцүү байна.

### **Гурав. Бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал**

“Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл” нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт дараах байдлаар туссан болно:

- ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.2.15-д “Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (**Зүрх судасны төв, ...**).” гэж;

- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.2.1-д “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /...**Зүрх судасны үндэсний төв**” гэж;

- “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 3.1.2.3-т “**Зүрх, судасны үндэсний төвийг барих**” гэж тус тус туссан.

### **Дөрөв. Төслийн хүрээнд хийгдэх ажил, хүрэх үр дүн**

Тус төслийн хүрээнд нийт 120 ортой эмнэлгийг барьж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

1.Зүрх судасны үндэсний төвийн барилгыг барих: Барилгын хувьд Улсын гуравдугаар төв эмнэлгийн үндсэн барилгад холбоотойгоор тус эмнэлгийн эзэмшлийн газарт барина;

2.Тоног төхөөрөмжийн шинэчлэл: Одоо хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийг шилжүүлэн байрлуулах ба зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчилж, шинээр худалдан авна;

3.Сургалт: Шинэ барилга, тоног төхөөрөмжийн орчинд ажиллах сургалт зохион байгуулагдахын зэрэгцээ улсын хэмжээнд зүрх судасны эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтуудыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

Шинэ барилга баригдсанаар мэс заслын өрөө 2 дахин, зүрх судсан дотуурх мэс заслын өрөө 2 дахин, үзлэгийн өрөө 3 дахин, оношилгооны өрөө 3 дахин нэмэгдэх ба бие даасан яаралтай тусламж, ахисан түвшний дүрс оношилгоо, өдрийн эмчилгээ, сэргээн засах эмчилгээний хэсэгтэй болно. Иргэд, эмчлүүлэгчид, эмнэлгийн хог хаягдлын урсгал 100% тусгаарлагдахаар зураг боловсруулагдсан нь ялангуяа халдварын эрсдэлийг эрс бууруулах юм. Мөн лаборатори, дүрс оношилгооны хэсэг, хоол, ариутгал зэргийг давхардуулан бий болгох шаардлагагүйгээр эмнэлгийн үндсэн тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, төрлийг нэмэгдүүлэх боломж олгох юм. Эмнэлгийн дотоод урсгал халдвар хамгааллын аюулгүй байдлыг бүрэн хангасан зөв урсгалтай байснаар эмчлүүлэгч нар тав тухтай орчинд аюулгүй, эрсдэлгүйгээр тусламж, үйлчилгээ авах, мэргэжилтнүүд эрсдэлгүйгээр тусламж, үйлчилгээ үзүүлэх таатай орчин бүрдэх болно.

### **Тав. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтад зааснаар Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан. Эдийн засаг 2026-2028 оны хооронд харгалзан 5.7 хувь, 6.3 хувь, 6.5 хувиар тус тус өсөж, Монгол Улсын 2026 оны төсөв, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд 43.8 хувь, 2027-2028 онуудад 42 орчим хувьтай байхаар тооцоологдсон. Ингэснээр дунд хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлага болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарыг хангахаар байна.

---o0o---

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг

(Үйл ажиллагааны дугаар 55677)

МОНГОЛ УЛС


болон

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

нарын хооронд байгуулсан


ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР  
(Монгол Улс GRСF3 W2- ЗСҮТ Төсөл)

Огноо 2025 оны [\_\_10 дугаар сарын 29-ний өдөр\_\_]



## АГУУЛГА

|                                                                                             |   |
|---------------------------------------------------------------------------------------------|---|
| НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ – СТАНДАРТ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁОНЫ<br>ТОДОРХОЙЛОЛТ .....                        | 2 |
| 1.01 дэх хэсэг. Стандарт Нөхцөлийг Хэрэглэх .....                                           | 2 |
| 1.02 дахь хэсэг. Нэр томьёоны тодорхойлолт .....                                            | 2 |
| 1.03 дахь хэсэг. Тайлбар .....                                                              | 3 |
| ХОЁРДУГААР ЗҮЙЛ – ЗЭЭЛИЙН ҮНДСЭН НӨХЦӨЛ.....                                                | 3 |
| 2.01 дэх хэсэг. Мөнгөн Дүн ба Валют.....                                                    | 3 |
| 2.02 дахь хэсэг. Зээлийн Бусад Санхүүгийн Нөхцөл.....                                       | 4 |
| 2.03 дахь хэсэг. Шууд Татан Авалт .....                                                     | 4 |
| 2.04 дэх хэсэг. Зээлийн Татан Авалт хийх Эрх Бүхий Этгээд.....                              | 5 |
| ГУРАВДУГААР ЗҮЙЛ - ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ .....                                                  | 5 |
| 3.01 дэх хэсэг. Хэрэгжүүлбэл Зохих Төслийн Бусад Үүрэг.....                                 | 5 |
| ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ - ТҮДГЭЛЗҮҮЛЭХ; ЗЭЭЛИЙН ЭРГЭН<br>ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГ ХУРДАСГАХ, ЦУЦЛАХ..... | 6 |
| 4.01 дэх хэсэг. Түдгэлзүүлэх.....                                                           | 6 |
| 4.02 дахь хэсэг. Зээлийн Эргэн Төлөлтийн Хугацааг Хурдасгах.....                            | 7 |
| ТАВДУГААР ЗҮЙЛ - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ.....                                                 | 7 |
| 5.01 дэх хэсэг. Хүчин Төгөлдөр Болох Урьдчилсан Нөхцөл.....                                 | 7 |
| 5.02 дахь хэсэг. Хууль Зүйн Дүгнэлт .....                                                   | 7 |
| 5.03 дахь хэсэг. Хэлэлцээр Хүчин Төгөлдөр Болоогүйгээс Дуусгавар<br>Болох.....              | 8 |
| ЗУРГААДУГААР ЗҮЙЛ – БУСАД ЗҮЙЛС .....                                                       | 8 |
| 6.01 дэх хэсэг. Мэдэгдэл .....                                                              | 8 |
| ХАВСРАЛТ 1 – ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....                                                       | 1 |
| ХАВСРАЛТ 2 - АНГИЛАЛ БА ЗЭЭЛ ТАТАН АВАЛТ.....                                               | 1 |



## ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

**ХЭЛЭЛЦЭЭРИЙГ МОНГОЛ УЛС** (цаашид “Зээлдэгч” гэх) болон **ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК** (цаашид “Банк” гэх) нарын хооронд 2025 оны [ 10 дугаар сарын 29 ]-ний өдөр байгуулав.

### УДИРТГАЛ

Банк нь олон намын тогтолцоот, ардчилсан, олон ургалч үзэлтэй, зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг хэрэгжүүлэхээр амласан бөгөөд хэрэгжүүлж буй улс орнуудын нээлттэй зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцыг хөхиүлэн дэмжихийн тулд тухайлсан төслүүдийг санхүүжүүлэх, мөн хувийн хэвшлийн бизнесийн санаачилга, төслийг дэмжих зорилготойгоор үүсгэн байгуулагдсан болохыг **ТЭМДЭГЛЭН**,

Хавсралт 1-д тодорхойлсон зүрх судасны шинэ эмнэлгийг Монгол Улсын Улаанбаатар хотод барихад дэмжлэг үзүүлэх Төслийг Зээлдэгч нь хэрэгжүүлэх зорилготой болохыг **ТЭМДЭГЛЭН**,

Зээлдэгчийн санхүүгийн туслалцаа, Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам (цаашид “Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллага” гэх)-ны дэмжлэгтэйгээр Төслийн А Хэсгийг Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг (цаашид “Төслийн Компани” гэх) хэрэгжүүлэхийг **ТЭМДЭГЛЭН**,

Зээлдэгч нь Төслийг санхүүжүүлэхэд туслалцаа үзүүлэхийг Банкнаас хүссэн болохыг **ТЭМДЭГЛЭН**,

Банк бусад зүйлүүд болон дээр дурдсаныг үндэслэн энэхүү Хэлэлцээр болон Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллага, Төслийн Компани ба Банкны хооронд байгуулах түүнд заасан өдөр байгуулах төслийн хэлэлцээр (Стандарт Нөхцөлд тодорхойлсноор “Төслийн Хэлэлцээр” гэх)-т заасан нөхцөл шаардлагаар зохицуулах 34,870,000 ам.долларын дүнтэй зээлийг Зээлдэгчид олгохыг зөвшөөрснийг **ТЭМДЭГЛЭН**,

Банк нь Зээлдэгчид Төслийн С Хэсгийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэхээр буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгох техникийн хамтын ажиллагааны хөрөнгө (цаашид “Техникийн Хамтын Ажиллагааны Хөрөнгө” гэх)-ийг авахаар ажиллаж байгааг **ТЭМДЭГЛЭН**,

Зээлдэгч нь Төслийн В, D болон E Хэсгүүдийг санхүүжүүлэхээр Люксембургийн Их Гүнт Улсын Люксембургийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Байгууллагаас санхүүжүүлэх, Зээлдэгч/Хүлээн авагч болон Люксембургийн Их Гүнт Улсын хоорондын буцалтгүй тусламжийн эсхүл хоёр талын хэлэлцээрийн нөхцөл шаардлагаар зохицуулах 22,500,000 евро хүртэл үнийн дүнтэй буцалтгүй тусламж авахаар ажиллаж байгааг **ТЭМДЭГЛЭН**,

ЕСБХБ-ны зээл болон Люксембургийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Байгууллагаас олгох буцалтгүй тусламж нь хамтдаа Төслийн санхүүжилтийг



ерөнхий бүтцийн салшгүй хэсгийг бүрдүүлэх ба тус бүр холбогдох хэлэлцээрээр зохицуулагдахыг **ТЭМДЭГЛЭН**,

**ИЙНХҮҮ**, талууд дор дурдсан нөхцөлийг үүгээр харилцан тохиролцов.

## **НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ – СТАНДАРТ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

### **1.01 дэх хэсэг. Стандарт Нөхцөлийг Хэрэглэх**

Банкны 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Стандарт Нөхцөлийн бүхий л зохицуулалт нь тэдгээрийг энэхүү Хэлэлцээрт бүрэн заасантай адил эрх зүйн хүчин чадалтай үйлчилж, дагаж мөрдөгдөнө.

### **1.02 дахь хэсэг. Нэр томьёоны тодорхойлолт**

Хэрэв энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй эсхүл агуулга нь өөрөөр шаардаагүй бол энэхүү Хэлэлцээр (үүнд Удиртгал болон Хавсралтууд мөн хамаарна)-г Удиртгалд заасан нэр томьёог түүнд харгалзах утгаар, Стандарт Нөхцөлд заасан нэр томьёог түүнд заасан утгаар, дараах нэр томьёог дор дурдсан утгаар тус тус ойлгоно. Үүнд:

"Зээлдэгчийн Эрх Бүхий  
Төлөөлөгч"

гэж Зээлдэгчийн Сангийн Сайдыг ойлгоно.

"КлайнтНэт"

гэж Банк болон түүний үйлчлүүлэгчийн хооронд баримт бичиг, мэдээлэл дамжуулах Банкны онлайн портал болон үүнийг орлох Банкны зүгээс Зээлдэгчид тухай бүр мэдэгдэх цахим хуудсыг ойлгоно.

"Барилгын Хяналтын  
Зөвлөх"

гэж Төслийн Хэлэлцээрт заасан утгаар ойлгоно.

"Зээлийн Хүүгийн  
Тохируулга"

гэж жилийн 0.608 хувийг (0.608%) ойлгоно.

"Албадан Хэрэгжүүлэх  
Бодлого, Журам"


гэж Банкны 2017 оны 10-р сарын 04-ний өдрийн Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журмыг ойлгоно.

"Санхүүгийн Жил"

гэж жил бүрийн 1-р сарын 1-ний өдөр эхлэх Зээлдэгчийн хуанлийн жилийг ойлгоно.

"Индекс Нийтэлсэн  
Хугацаа"

гэж 15:00 цаг (Нью Йорк хотын цагаар) (эсвэл А Банкнаас Зээлдэгчид мэдэгдсэн өөр цаг)-ыг ойлгоно.



|                                                    |                                                                                                                                                                                                                                                                           |
|----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| "Индекс Нийтлэгч"                                  | гэж Администраторыг ойлгоно.                                                                                                                                                                                                                                              |
| "Индексийг Лавлах<br>Хуудас"                       | гэж <a href="https://www.newyorkfed.org/markets/reference-rates/sofr-averages-and-index">https://www.newyorkfed.org/markets/reference-rates/sofr-averages-and-index</a> (эсхүл үүнийг орлон эсхүл өөрчлөн Администраторын цахим хуудас дээр гарч ирэх хуудас)-ыг ойлгоно. |
| "Зээлийн Валют"                                    | гэж Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгт америк долларыг ойлгоно.                                                                                                                                                                                            |
| "Төсөл Дуусгавар<br>Болох Өдөр"                    | гэж зүрх судасны шинэ эмнэлгийг барьж, тоног төхөөрөмжөө суурилуулж, үйл ажиллагаагаа эхэлснээ Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллага эсхүл Төслийн Компани ЕСБХБ-нд баталгаажуулсан өдрийг ойлгоно.                                                                              |
| "Төсөл Хэрэгжүүлэхэд<br>Дэмжлэг Үзүүлэх<br>Зөвлөх" | гэж Төслийн Хэлэлцээрт заасан утгаар ойлгоно.                                                                                                                                                                                                                             |
| "Төсөл Хэрэгжүүлэх<br>Нэгж эсхүл ТХН"              | гэж 3.01(b)(1) дэх хэсгийн дагуу байгуулах нэгжийг ойлгоно.                                                                                                                                                                                                               |
| "Төсөл Хэрэгжүүлэх<br>Нэгжийн Ажлын<br>Даалгавар"  | гэж Банкнаас урьдчилан зөвшөөрөл авч, тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болох Банкнаас зөвшөөрсөн, Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагаас батлах Төсөл Хэрэгжүүлэх Нэгжийн бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагааг тодорхойлсон ажлын даалгаврыг ойлгоно.                             |

### 1.03 дахь хэсэг. Тайлбар

Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт аливаа Зүйл, Хэсэг эсхүл Хавсралтыг дурдсан бол энэхүү Хэлэлцээрийн тэрхүү Зүйл, Хэсэг, Хавсралтыг хэлж байгаа гэж ойлгоно.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ – ЗЭЭЛИЙН ҮНДСЭН НӨХЦӨЛ

### 2.01 дэх хэсэг. Мөнгөн Дүн ба Валют

Банк нь энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөл шаардлагын дагуу 34,870,000 (гучин дөрвөн сая найман зуун далан мянган) ам. долларын мөнгөн дүнг Зээлдэгчид зээлдүүлэхийг зөвшөөрч байна.



## 2.02 дахь хэсэг. Зээлийн Бусад Санхүүгийн Нөхцөл

- (a) Зээл Татан Авалтын Доод Хэмжээ 300,000 ам. доллар байна.
- (b) Зээл Хугацаанаас Өмнө Төлөх Доод Хэмжээ 3,000,000 ам. доллар байна.
- (c) Зээл Цуцлах Доод Хэмжээ 500,000 ам. доллар байна.
- (d) Хүү Төлөх Өдөр жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдөр болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.
- (e) (1) Зээлдэгч нь Зээлийг хагас жил тутамд жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдөр болон 10 дугаар сарын 15-ны өдөр, 28 удаагийн тэнцүү (эсхүл аль болох тэнцүү) хуваарилалтаар эргэн төлөх бөгөөд эхний Зээл Эргэн Төлөх Өдөр нь энэхүү Хэлэлцээрийг байгуулсны 4 дэх жилийн ойн өдрийн дараа тохиох эхний Хүү Төлөх Өдөр, Зээл Эргэн Төлөх Сүүлчийн Өдөр нь энэхүү Хэлэлцээрийг байгуулсны 18 дахь жилийн ойн өдрийн дараа тохиох Хүү Төлөх Өдөр байна.  
  
(2) Дээр заасныг үл харгалзан, хэрэв (i) Зээлдэгч нь нийт Зээлийн дүнг энэхүү 2.02.(e) хэсэгт заасан эхний Зээл Эргэн Төлөх Өдрөөс өмнө татан аваагүй, болон (ii) Банк нь доорх 2.02.(f) хэсэгт заасан Зээл Олгох Сүүлчийн Өдрийг тэрхүү эхний Зээл Эргэн Төлөх Өдрөөс хойш аль нэг өдөр байхаар сунгасан бол эхний Зээл Эргэн Төлөх Өдөр эсхүл түүнээс хойших өдөр хийгдсэн зээлийн татан авалт бүрийн дүнг тэрхүү татан авалтын өдрөөс хойших хэд хэдэн Зээл Эргэн Төлөх Өдрүүдэд тэнцүү хэмжээгээр эргэн төлөхөөр ногдуулж хуваарилна (тухай бүрд бүхэл тоо байлгах шаардлагатай бол тийнхүү хуваарилах тухайн дүнд Банк тохируулга хийнэ). Банк нь ийнхүү хуваарилсан дүнгийн талаар Зээлдэгчид тухай бүр мэдэгдэнэ.
- (f) Зээл Олгох Сүүлчийн Өдөр нь энэхүү Хэлэлцээрийг байгуулсны 7 дахь жилийн ойн өдөр эсхүл уг өдрөөс хойших Банкны тогтоож болох, Зээлдэгчид мэдэгдэх өдөр байна.
- (g) Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж хувь жилийн 0.5% байна.
- (h) Зээл Хувьсах Хүүгийн Хувьтай байна.

## 2.03 дахь хэсэг. Шууд Татан Авалт

- (a) Зээлдэгч Зээлийн Боломжит Дүнг Хавсралт 2-т заасны дагуу Төсөлд шаардагдах бараа, ажил, үйлчилгээний гарсан (эсхүл хэрэв Банк зөвшөөрсөн бол гарах) үндэслэлтэй зардлыг санхүүжүүлэхээр тухай бүр татан авч болно.
- (b) Зээлдэгч нь Зээлийн Боломжит Дүнгээс Зээл Олголтын Урьдчилсан Шимтгэлийг төлөхгүй гэж сонговол оронд нь өөрийн эх үүсвэрээс Зээл Олголтын Урьдчилсан Шимтгэлийг төлнө. Зээлдэгч нь Зээл Олголтын Урьдчилсан Шимтгэлийн төлбөрийг Стандарт Нөхцөлийн 3.05(d) дахь хэсгийн дагуу төлнө.



## **2.04 дэх хэсэг. Зээлийн Татан Авалт хийх Эрх Бүхий Этгээд**

Монгол Улсын Сангийн Сайд нь Стандарт Нөхцөлийн 2.03(а), 3.01 болон 3.02 хэсэгт заасны дагуу шаардлагатай эсхүл зөвшөөрөгдсөн аливаа үйлдлийг хийх зорилгоор Зээлдэгчийн Эрх Бүхий Этгээд байна.

## **ГУРАВДУГААР ЗҮЙЛ - ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

### **3.01 дэх хэсэг. Хэрэгжүүлбэл Зохих Төслийн Бусад Үүрэг**

Банк өөрөөр зөвшөөрөөгүй бол Стандарт Нөхцөлийн IV болон V дугаар зүйлд заасан ерөнхий нөхцөлөөс гадна Зээлдэгч нь дараах үүргийг хүлээнэ:

(a) Төслийг хэрэгжүүлэхээр Зээл болон Техникийн Хамтын Ажиллагааны Хөрөнгийг Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагад олгоно;

(b) Төсөл Хэрэгжүүлэх Нэгжид санхүүжилт олгоно (Төслийн E Хэсгийн дагуу);

(c) Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллага, Төслийн Компаниар тэдгээрийн Төслийн Хэлэлцээрээр хүлээсэн бүх үүргийг биелүүлэх, үүнд дор дурдсан үүргүүд багтах бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(1) Төслийн Хэлэлцээрийн 2.02 дахь хэсэгт заасны дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, ажиллуулах;

(2) Төслийн Хэлэлцээрийн 2.03 дахь хэсэгт заасны дагуу Төслийн бараа, ажил, үйлчилгээ болон зөвлөх үйлчилгээг худалдан авах;


(3) Төслийн Хэлэлцээрийн 2.04 дэх хэсэгт заасны дагуу байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

(4) Төслийн Хэлэлцээрийн 2.05 дахь хэсэгт заасны дагуу Төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөхийг ажиллуулах;

(5) Төслийн Хэлэлцээрийн 2.06 дахь хэсэгт заасны дагуу Төсөлтэй холбоотой асуудлуудын болон Төслийн Компанийн үйл ажиллагааны тайланг боловсруулах, хүргүүлэх;

(6) Төслийн Хэлэлцээрийн 3.01 дэх хэсэгт заасны дагуу санхүүгийн дүрэм журмыг хэрэгжүүлэх, данс, бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан боловсруулах, аудит хийлгэж Банканд хүргүүлэх, Төсөл, Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллага болон Төслийн Компанийн үйл ажиллагаатай холбоотой бусад холбогдох мэдээллээр Банкныг хангах;

(7) Төслийн Хэлэлцээрийн 3.02 дахь хэсэгт заасны дагуу Төсөл болон Төслийн Компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбоотой бүхий л үүргийн хэрэгжүүлэх;



- (8) Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Ард Аюушийн өргөн чөлөө - 2, 10-р хороололд байрлах Төслийн Компанийн барилга байгууламжийн дэргэд шинэ эмнэлэгт шаардагдах газрыг олгох.
- (9) Төсөл Дуусгавар Болох Өдрөөс хойш 6 сарын дотор Төслийн дагуу баригдсан барилгад үндэсний Барилгын эрчим хүчний А+ (ЕРС) гэрчилгээ авах;
- (d) Төсөл Дуусгавар Болох Өдөр Төслийг хэрэгжүүлж дуусахад шаардлагатай хөрөнгийг олгоход шаардагдах бүхий л нэмэлт үйл ажиллагааг хийж гүйцэтгэх, эсхүл гүйцэтгүүлсэн байх, үүнд дараах зүйлс багтана,
- (1) Банк хүлээн зөвшөөрөхүйц, ТХН-ийн Ажлын Даалгаврын дагуу ажилд авсан, шаардлага хангасан ажиллах хүчний нөөцтэй Төсөл Хэрэгжүүлэх Нэгжид Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагаас холбогдох төслийн хүрээнд багтаан хангалттай санхүүжилт олгох;
- (2) Төсөл Дуусгавар Болох Өдрөөс өмнө Төслийн байгууламжууд бүрэн ажиллагаатай байхад шаардлагатай эмнэлгийн болон эмчилгээний бүхий л тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагаа хийгдсэн байх явдлыг хангуулахаар Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагаас санхүүжилт олгох (эсхүл Төсөл Дуусгавар Болох Өдрөөс өмнө тэрхүү шаардлагатай эмнэлгийн болон эмчилгээний бүхий л тоног төхөөрөмжийг Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагаас олгох);
- (3) Үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний зардлыг оролцуулаад Төсөл хэрэгжүүлэхэд хангалттай санхүүжилтийг Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагаас олгох;
- (e) Банкнаас олгох Зээл болон Техникийн Хамтын Ажиллагааны Хөрөнгөөс санхүүжүүлэх бүхий л бараа, ажил, үйлчилгээ (үүнд зөвлөх үйлчилгээ багтана)-г татвар (үүнд НӨАТ багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй) болон гаалийн албан татвар (гаалийн хураамжийг оролцуулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй)-аас чөлөөлөх.

## **ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ - ТҮДГЭЛЗҮҮЛЭХ; ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГ ХҮРДАСГАХ**

### **4.01 дэх хэсэг. Түдгэлзүүлэх**

Стандарт Нөхцөлийн 7.01(a)(xvii) хэсгийн зорилгод дор дурдсаныг тодотгож байна:

- (a) Банк бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Зээлдэгчийн нутаг дэвсгэрт эрүүл мэндийн салбарт үйлчлэх хууль тогтоох болон захиргааны тогтолцоо өөрчлөгдөж, түдгэлзэж, цуцлагдаж, хүчингүй болсон, эсхүл тэдгээрийн үйлчлэлээс татгалзсан;



(b) хууль өөрчлөгдөж, түдгэлзэж, цуцлагдаж, хүчингүй болсон, эсхүл тэдгээрийн үйлчлэлээс татгалзсан;

(c) Төслийн Компанийн хяналтыг Зээлдэгчээс өөр талд шилжүүлсэн;

(d) Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллага ба/эсхүл Төслийн Компани нь тэдгээрийн Төслийн Хэлэлцээрт заасан үүргээ зөрчсөн.

#### **4.02 дахь хэсэг. Зээлийн Эргэн Төлөлтийн Хугацааг Хурдасгах**

Стандарт Нөхцөлийн 7.06(f) хэсгийн зорилгод дор дурдсаныг тодотгож байна: дээрх 4.01 дэх хэсэгт дурдсан аль нэг нөхцөл байдал.

### **ТАВДУГААР ЗҮЙЛ - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛ**

#### **5.01 дэх хэсэг. Хүчин Төгөлдөр Болох Урьдчилсан Нөхцөл**

Стандарт Нөхцөлийн 9.02(c) хэсгийн зорилгод энэхүү Хэлэлцээр болон Төслийн Хэлэлцээр хүчин төгөлдөр болох дараах нэмэлт урьдчилсан нөхцөлүүдийг тодотгож байна:

(a) Төслийн Хэлэлцээрийг байгуулж, талуудад хүргүүлсэн байх, Зээлийн Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдлаас бусад түүний хүчин төгөлдөр болох бүхий л урьдчилсан нөхцөлүүд бүрэн биелэгдсэн байна.


#### **5.02 дахь хэсэг. Хууль Зүйн Дүгнэлт**

(a) Стандарт Нөхцөлийн 9.03(a) хэсгийн зорилгод Зээлдэгчийн нэрийн өмнөөс Хууль Зүй, Дотоод Хэргийн Сайд хууль зүйн дүгнэлт эсхүл дүгнэлтүүдийг гаргасан байна.

(b) Стандарт Нөхцөлийн 9.03(c) хэсгийн зорилгод Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагын нэрийн өмнөөс түүний дотоод хуульч зөвлөх хууль зүйн дүгнэлт эсхүл дүгнэлтүүдийг гаргах ба Банканд хүргүүлэх уг хууль зүйн дүгнэлт эсхүл дүгнэлтүүдэд тусгах доорх нэмэлт зүйлсийг тодотгож байна:

(1) Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллага нь Төслийн Хэлэлцээрийг байгуулах бүрэн эрхтэй, эсхүл баталсан, байгуулсан, түүний нэрийн өмнөөс нөгөө талд хүргүүлсэн бөгөөд Төслийн Хэлэлцээр нь Төсөл Хэрэгжүүлэгч Байгууллагын хуулийн хүчин төгөлдөр үүргийг үүсгэж, түүний нөхцөлийн дагуу албадан биелүүлэх хууль зүйн хүчин чадалтай болно.

(c) Стандарт Нөхцөлийн 9.03(c) хэсгийн зорилгод Төслийн Компанийн нэрийн өмнөөс түүний зөвлөх хууль зүйн дүгнэлт эсхүл дүгнэлтүүдийг гаргах ба Банканд хүргүүлэх уг хууль зүйн дүгнэлт эсхүл дүгнэлтүүдэд тусгах доорх нэмэлт зүйлсийг тодотгож байна:



(1) Төслийн Гэрээ нь Төслийн Компанийн зүгээс зохих ёсоор зөвшөөрөгдөж, баталгаажуулагдан, гарын үсэг зурж, хүлээлгэн өгсөн бөгөөд тухайн гэрээ нь Төслийн Компанид хүчин төгөлдөр, хууль ёсны үүрэг хүлээлгэгч баримт бичиг бөгөөд түүний нөхцөл, заалтын дагуу Төслийн Компанид хуулийн дагуу хэрэгжих боломжтой байна.

### 5.03 дахь хэсэг. Хэлэлцээр Хүчин Төгөлдөр Болоогүйгээс Дуусгавар Болох

Стандарт Нөхцөлийн 9.04 дэх хэсгийн зорилгод Хэлэлцээрийг байгуулсан өдрөөс хойш 365 хоногийн дараах өдөр болохыг тодотгож байна.

## ЗУРГААДУГААР ЗҮЙЛ – БУСАД ЗҮЙЛС

### 6.01 дэх хэсэг. Мэдэгдэл

(a) Стандарт Нөхцөлийн 10.01 дэх хэсгийн зорилгод аливаа мэдэгдлийг гарт нь хүргүүлэх, шуудангаар эсхүл цахим шуудангаар, пдф эсхүл төсөөтэй хэлбэрээр илгээснээс бусад тохиолдолд дараах хаягт хүргүүлэхийг тодотгож байна:

Зээлдэгчид:

Монгол Улс  
Монгол Улсын Сангийн Яам  
Засгийн газрын II байр  
Данзангийн гудамж 5/1  
Улаанбаатар 15160, Монгол Улс

Хэнд: [ Сангийн яамны Санхүүгийн Бодлогын газрын Өрийн  
Удирдлагын хэлтэс ]

И-мэйл: [ debt\_service@mof.gov.mn ]

ЕСБХБ-д:

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк  
5 дугаар банкны гудамж  
Лондон хот E14 4БЖ  
Их Британи Улс

Хэнд: Банкны Үйлчилгээ / Үйл ажиллагааны № 55677

Утас: +44 20 7338 6000

И-мэйл: [bankingservices@ebrd.com](mailto:bankingservices@ebrd.com)

(b) Банк нь Зээлдэгчийг КлайнтНэт эсхүл цахим харилцаа холбооны өөр хэлбэрийг хэрэглэхийг санал болгож болох ба хэрэв Зээлдэгч болон Банк А КлайнтНэт эсхүл цахим харилцааны өөр хэлбэрийг хэрэглэхээр тохирсон


МОНГОЛ УЛСЫН САНГИЙН  
ЯАМЫН ЭСНЭН ОРЧУУЛГА МОН  
ЗЭЭЛДЭГЧ /Sgnalgr/  
25 10 29  
Улаанбаатар хот

тохиолдолд Зээлдэгчээс Банканд эсхүл Банкнаас Зээлдэгчид илгээх (энэхүү Хэлэлцээр [эсхүл аливаа бусад Санхүүжилтийн Хэлэлцээр]-ээр эх хувиар, гэрчлэгдсэн хуулбараар эсхүл цаасаар байхаар шаардсан мэдэгдэл, өргөдөл, эсхүл бусад харилцаа холбооноос бусад) аливаа мэдэгдэл, өргөдөл, эсхүл бусад харилцаа холбоо нь КлайнтНэт эсхүл тухайн харилцаа холбооны бусад хэлбэрийн нөхцөл, шаардлагын хүрээнд, КлайнтНэтэд тухайн мэдэгдэл, өргөдөл, эсхүл бусад харилцаа холбоог байришуулж эсхүл тохиролцсон бусад харилцаа холбооны нөхцөл, шаардлагын дагуу илгээж болно.

(с) Биечлэн, агаарын шуудангаар, факсаар эсхүл КлайнтНэт эсхүл тохиролцсон цахим харилцаа холбооны бусад хэлбэрээр хүргэсэн аливаа мэдэгдэл, өргөдөл, эсхүл бусад харилцаа холбоо нь зөвхөн унших боломжтой байдлаар, бодитоор хүлээн авсан (эсхүл боломжтой болсон) тохиолдолд хүчинтэйд тооцогдоно. Энэ тохиолдолд тухайн мэдэгдэл, өргөдөл, эсхүл бусад харилцаа холбоог 17:00 цагаас хойш, тухайн мэдэгдэл, өргөдөл, эсхүл бусад харилцаа холбоог хүлээн авах талын энэхүү Хэлэлцээрийн зорилгод түүний хаягийг зааж хүргүүлсэн (эсхүл боломжтой болсон) бол тэдгээрийг дараагийн өдрөөс хүчин төгөлдөр болсонд тооцно.

(d) Банкнаас КлайнтНэттэй:<sup>2</sup> холбогдуулан аливаа урилга явуулах зорилгоор холбогдохоор эхний ээлжинд томилогдсон Зээлдэгчийн холбоо барих этгээдийн нэр, албан тушаал, и-мэйл хаягийг дор дурдаж байна. КлайнтНэтийг хэрэглэхэд групп и-мэйл хаягууд бүртгэгдэхгүй тул дор дурдсан и-мэйл хаягууд зөвхөн хувь хүнийх байхыг анхаарна уу.

| Нэр                     | Албан тушаал                       | И-мэйл хаяг             | Хэл – Англи, Орос, Франц |
|-------------------------|------------------------------------|-------------------------|--------------------------|
| Өрийн Удирдлагын Хэлтэс |                                    | debtservice@mof.gov.mn  | Англи                    |
| Лувсандоржийн Гантогтох | Өрийн Удирдлагын хэлтсийн дарга    | Gantogtokh_l@mof.gov.mn | Англи                    |
| Булганхүүгийн Ганзориг  | Хөгжлийн Санхүүжилт хэлтсийн дарга | Ganzorig_b@mof.gov.mn   | Англи                    |



**ДЭЭР ДУРДСАНЫГ ГЭРЧЛЭН**, энэхүү Хэлэлцээрийн талууд өөрийн зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчөөрөө дамжуулан дээр дурдсан өдөр [гурван] хувь энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурж, [Их Британи Улс, Лондон]-д хүргүүлсэн болно.

## **МОНГОЛ УЛС**

Гарын үсэг: \_\_\_\_\_

Нэр:


Албан тушаал:

## **ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК**

Гарын үсэг: \_\_\_\_\_

Нэр:

Албан тушаал:



## ХАВСРАЛТ 1 – ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Төслийн зорилго нь Улаанбаатар хотод 120 орчим орны хүчин чадалтай зүрх судасны шинэ эмнэлэг барихад Зээлдэгчид дэмжлэг үзүүлэх болно.

2. Төсөл нь дараах Хэсгүүдээс бүрдэх бөгөөд Банк болон Зээлдэгч нар тухай бүр тохиролцон өөрчлөлт оруулж болно:

А Хэсэг: 120 орчим орны хүчин чадалтай зүрх судасны шинэ эмнэлэг барих (үүнд тавилга, тэмдэглэгээ, бусад эмнэлгийн бус дэд бүтцийг оролцуулаад эмнэлгийн барилга байгууламжийн ерөнхий тоноглол багтана, харин эмнэлгийн тоног төхөөрөмжүүд орохгүй).


В Хэсэг: Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх.

С Хэсэг: Төсөл Хэрэгжүүлэхэд Үзүүлэх Дэмжлэг.

Д Хэсэг: Барилгын Хяналтын Дэмжлэг.

Е Хэсэг: Төсөл Хэрэгжүүлэх Нэгжийн үйл ажиллагааны болон захиргааны зардал (ажиллагсдыг оролцуулаад).

3. Төсөл Дуусгавар Болох Өдөр 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байхаар төлөвлөсөн.



## ХАВСРАЛТ 2 - АНГИЛАЛ БА ЗЭЭЛ ТАТАН АВАЛТ

1. Энэхүү Хавсралтын хүснэгтэд Ангилал, Ангилал тус бүрд ногдох Зээлийн хэмжээ, Ангилал тус бүр дэх санхүүжүүлэх зардлын хувийг тусгасан болно.

2. Дээрх 1 дүгээр зүйлд заасныг үл хамааран, дор дурдсанд Зээл Татан Авалт хийхгүй:


(а) дор дурдсан нөхцөл тус бүр хангагдсаныг Банк хүлээн зөвшөөрөх хүртэл:

(1) Банк хүлээн зөвшөөрөхүйц ажлын даалгаврын дагуу хангалттай нөөц болон шаардлага хангасан ажиллах хүчин ажилд авч, ТХН-ийг үүсгэн байгуулж, түүний үйл ажиллагааг шаардлагатай хэмжээгээр бүрэн санхүүжүүлсэн байх;

(2) Банк хүлээн зөвшөөрөхүйц ажлын даалгаврын дагуу Төсөл Хэрэгжүүлэхэд Дэмжлэг Үзүүлэх Зөвлөхийг сонгож, гэрээ байгуулсан байх;


(3) Зээлдэгч нь Төслийн бүрэлдэхүүн хэсгээс дотоодын санхүүжилтээр санхүүжүүлэх шаардлагатай хөрөнгийг төсвийн хүрээнд баталсан эсхүл олон улсын хандивлагч байгууллагын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр байгуулсан гэрээний аль хамааралтайгаас зохих ёсоор, бүрэн хэмжээгээр баталгаажсаныг Банк хүлээн зөвшөөрөхүйц баримт нотолгоо гаргасан байх.

(b) Зээлийн Хэлэлцээрийн өдрөөс өмнө гарсан зардал.



## Хавсралт 2. Хүснэгт

| Ангилал                                 | Зээлийн Валютаар олгох<br>Зээлийн Дүн | Санхүүжүүлэх Зардлын Хувь                                                |
|-----------------------------------------|---------------------------------------|--------------------------------------------------------------------------|
| (1) А Хэсгийн Бараа, Ажил,<br>Үйлчилгээ | 34,870,000 ам. доллар                 | Аливаа Татвар<br>оролцуулахгүйгээр<br>хэлэлцээрийн үнийн дүнгийн<br>100% |
| Нийт                                    | 34,870,000 ам. доллар                 |                                                                          |



Execution Copy  
(Operation Number 55677)

**LOAN AGREEMENT**

(Mongolia GRCF3 W2-Project NCC)

between

**MONGOLIA**

and

**EUROPEAN BANK  
FOR RECONSTRUCTION AND DEVELOPMENT**

Dated 29 October 2025

## TABLE OF CONTENTS

|                                                                    |   |
|--------------------------------------------------------------------|---|
| ARTICLE I - STANDARD TERMS AND CONDITIONS; DEFINITIONS .....       | 2 |
| Section 1.01. Incorporation of Standard Terms and Conditions ..... | 2 |
| Section 1.02. Definitions .....                                    | 2 |
| Section 1.03. Interpretation .....                                 | 3 |
| ARTICLE II - PRINCIPAL TERMS OF THE LOAN .....                     | 3 |
| Хуулийн төсөл боловсруулах | <p>Өөрчлөхөөр тулгамдаж байгаа асуудал нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд тус тус заасны дагуу хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэхээр байна.</p>                                                                                                                                                                                                                                                                                                  | <p>Хуулийн төсөлтэй холбогдуулан 34.8 сая ам долларын зээлийн санхүүжилт гарч байгаа хэдий ч үүний үр дүнд Монгол хүн эх орондоо оношлуулж, эмчлэгдэх боломж бүрдэхийн зэрэгцээ, тусламж үйлчилгээний хүлээгдэл чирэгдэл буурах, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх боломж нэмэгдэнэ. Улмаар хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй зүрх судасны эмгэгийн шалтгаан нас баралтыг бууруулах боломж бүрдэнэ хэмээн үзэж байна.</p> |

**ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын”-ын дагуу Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа аргачлалд заасан дор дурдсан суурт асуултуудыг ашиглан төсөл тус бүр дээр судалгааг хийлээ.

#### 6.1. Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

##### Хүснэгт 1

#### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө                                   | Холбогдох асуулт                                                                                                                                                                                 | Хариулт |      | Тайлбар                                                                                                                                    |
|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх                                                                                                                                                         |         |      |                                                                                                                                            |
|                                                    | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх                                                                                                                                                       | Тийм    |      | Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн хүн бүр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрх тэгш боломжийг бүрдүүлнэ |
|                                                    | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх                                                                                                                         |         | Үгүй |                                                                                                                                            |
|                                                    | 1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм    |      |                                                                                                                                            |
|                                                    | 1.2.Оролцоог хангах                                                                                                                                                                              |         |      |                                                                                                                                            |
|                                                    | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн                                                                                                  | Тийм    |      | Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүн бүр амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ                   |

|                                                       |                                                                                                                                                                 |      |      |                                                                                                                                                                              |
|-------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                       | оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх                                                                                                                               |      |      | авах эрхийг баталгаажуулна                                                                                                                                                   |
|                                                       | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх                      | Тийм |      |                                                                                                                                                                              |
|                                                       | 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага                                                                                                           |      |      |                                                                                                                                                                              |
|                                                       | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх                                                  | Тийм |      | Энэхүү хувилбар нь Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимтай нийцэж байгаа |
|                                                       | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | Тийм |      |                                                                                                                                                                              |
|                                                       | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх                                                                                                 |      |      | хамааралгүй                                                                                                                                                                  |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх                                                             |      | Үгүй | Хуулиар хүний эрхийг хязгаарлаагүй                                                                                                                                           |
|                                                       | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх                                                                                                                        |      | Үгүй |                                                                                                                                                                              |

|                                                                  |                                                                                                                                                                                                    |      |      |                                                                               |
|------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|-------------------------------------------------------------------------------|
| 3.Эрх агуулагч[8]                                                | 3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх                                                                                                                | Тийм |      | Монгол Улсын Засгийн газар болон холбогдох төрийн захиргааны төв байгууллага  |
|                                                                  | 3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх                                                                                                                                      |      |      | хамааралгүй                                                                   |
|                                                                  | 3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх                                                                  | Тийм |      | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.                       |
|                                                                  | 3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй) |      | Үгүй | Хүн бүр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр тусгасан |
| 4.Үүрэг хүлээгч[9]                                               | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх                                                                                                                                                            | Тийм |      | Хэлэлцээрт оролцогч төрийн байгууллагууд                                      |
| 5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх                                                                                                                                                       | Тийм |      | Хүний эрхийн ерөнхий зарчмын хүрээнд тодорхойлогдоно                          |
|                                                                  | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх                                                                                                          | Тийм |      |                                                                               |

# ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 2

| Үзүүлэх үр нөлөө                                               | Холбогдох асуулт                                                                                                           | Хариулт |      | Тайлбар                                                                                                      |
|----------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар                        | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх        | Тийм    |      | Эрүүл мэндийн салбарт дотоодын эмнэлгийн өрсөлдөх чадварыг сайжруулна                                        |
|                                                                | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | Тийм    |      | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зорилгоор гадаад орон руу чиглэх эмчлүүлэгчийн урсгалыг бууруулна         |
|                                                                | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх                 | Тийм    |      | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжирснаар гадаад орон руу чиглэх эмчлүүлэгчийн урсгалыг бууруулна |
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх                                                                  |         | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                |
|                                                                | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх                                                    |         | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                |
|                                                                | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх                                      |         | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                |

|                                                                  |                                                                                                                      |      |      |                                                                                                                                              |
|------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                  | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх                                                                      |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                                |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал         | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх                                 | Тийм |      | Тусламж үйлчилгээний цар хүрээ нэмэгдэх, шинэ техник технологи нэвтрэхтэй холбоотой нэмэгдэх боломжтой                                       |
|                                                                  | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх                                                            | Тийм |      | Үйлчилгээний цар хүрээ, тоо хэмжээ нэмэгдэх мөн Олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх байдлаар санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэх боломжтой |
|                                                                  | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх                                           |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                                |
|                                                                  | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх                                   |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                                |
|                                                                  | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх                                                          |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                                |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                                |

|                                     |                                                                                                               |      |      |                                                                                                                                   |
|-------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 5.Өмчлөх эрх                        | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                     |
|                                     | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх                            |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                     |
|                                     | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх    |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөө гарахгүй                                                                                                     |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх                                   | Тийм |      | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орчин үеийн шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой                       |
|                                     | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх   | Тийм |      |                                                                                                                                   |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв  | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх                                                              |      | Үгүй | Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих учир хэрэглэгч болон гэр бүлийн төсөвт нөлөөлөхгүй хэмээн үзэж байна. |
|                                     | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх                                        | Тийм |      | Эх орондоо оношлогдон эмчлэгдэх боломж өргөжиж                                                                                    |
|                                     | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх                                                                     | Тийм |      | хэрэглэгчийн эрх ашигт эерэгээр нөлөөлнө.                                                                                         |

|                                 |                                                                                                                  |      |      |                                                                                                                                                                                     |
|---------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                 |                                                                                                                  |      |      |                                                                                                                                                                                     |
|                                 | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх                 | Тийм |      | Гадаад эмчилгээнд явах зардлыг бууруулснаар санхүүгийн эерэг нөлөөлөл үзүүлнэ                                                                                                       |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх                            | Тийм |      | Төвийн үйл ажиллагаатай холбоотой төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтнийг дангаар болон ажил үйлчилгээг хавсруулан сургаж бэлтгэх чиглэл баримтална. |
|                                 | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх               |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                                             |
|                                 | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх                                                |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                                             |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх                                                                              | Тийм |      | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ өргөжиж байгаатай холбоотой улсын төсөв нэмэгдэх боломжтой                                                                                          |
|                                 | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх |      | Үгүй | Одоогийн ажиллаж байгаа төрийн байгууллагын бүтцийн хүрээнд өргөжүүлэн ажиллуулах боломжтой                                                                                         |

|                                |                                                                                           |      |      |                                                                                                                                                                                                  |
|--------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх                         |      | Үгүй |                                                                                                                                                                                                  |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх                 | Тийм |      | Зүрх судасны өвчний шалтгаант өвчлөл нас баралтыг бууруулснаар хүний эрүүл идэвхтэй амьдралыг илүү уртасгаж ХЧТА-ыг бууруулах улмаар улсын эдийн засгийн өсөлтөд “эерэг” нөлөө үзүүлэх боломжтой |
|                                | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | Тийм |      | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд төдийгүй хувь хүн, гэр бүл, хамт олны эрүүл мэндийн байдалд чухал хөрөнгө оруулалт болно.                                                                      |
|                                | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх                                                                |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                                                          |
| 11.Олон улсын харилцаа         | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх                                  | Тийм |      | Ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй                                                                                                                                                                 |

### НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

| Үзүүлэх үр нөлөө                               | Холбогдох асуулт                     | Хариулт |  | Тайлбар                                                        |
|------------------------------------------------|--------------------------------------|---------|--|----------------------------------------------------------------|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | Тийм    |  | Орчин үеийн оношилгоо эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэхтэй |

|                                   |                                                                                              |      |      |                                                                                                                                                     |
|-----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|------|------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                   |                                                                                              |      |      | холбоотой шинээр ажлын байр бий болох боломжтой                                                                                                     |
|                                   | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх                            |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөгүй                                                                                                                           |
|                                   | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх    |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөгүй                                                                                                                           |
|                                   | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх                           |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөгүй. Харин эсрэгээр тусламж үйлчилгээний хүртээмж сайжирч ХЧТА-ыг бууруулах боломжтой.                                        |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх                                                    | Тийм |      | Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг бүрэн хангасан орчныг бүрдүүлнэ .                                                                           |
|                                   | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх                           | Тийм |      |                                                                                                                                                     |
|                                   | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх                                | Тийм |      | Оношилгоо, эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой ажлын байрны стандарт шинэчлэгдэх болон бусад дагалдах эерэг өөрчлөлт гарах боломжтой |
|                                   | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх                                                        | Тийм |      |                                                                                                                                                     |
|                                   | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | Тийм |      |                                                                                                                                                     |
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг       | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх                                       |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй.                                                                                                                            |

|                                                                                  |                                                                                                                                                        |      |      |                                                                                                                                                              |
|----------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| хамгаалах асуудал                                                                | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт |      | Үгүй | Тусламж, үйлчилгээг хүн бүр тэгш, хүртээмжтэй хүргэх зорилготой                                                                                              |
|                                                                                  | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх                                                                                                             |      | Үгүй |                                                                                                                                                              |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх                                                                                                    |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                      |
|                                                                                  | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх                                                                                        |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                      |
|                                                                                  | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх                                                                              |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                      |
|                                                                                  | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх                                                                                 |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                      |
|                                                                                  | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх                                                                              |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                                                      |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал                                             | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх                                                                 | Тийм |      | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судасны эмгэгийг шалтгаант өвчлөлийг |

|                                                      |                                                                                                                                     |      |      |                                                                                                                                                                                                    |
|------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                      |                                                                                                                                     |      |      | эрт илрүүлэх, цаг бус нас баралтыг бууруулах ач холбогдолтой.                                                                                                                                      |
|                                                      | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх |      | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөөгүй                                                                                                                                                                          |
|                                                      | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх                                      | Тийм |      | Зүрх судасны эмгэг үүсэх гол шалтгаан болсон хөдөлгөөний дутагдал, зөв хооллолт, архи, тамхины хор хөнөөлийн эсрэг нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг давхар хэрэгжүүлнэ |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх                                                                           | Тийм |      | Нийгмийн суурь үйлчилгээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж тусламж, үйлчилгээ авах иргэдийн хүлээгдэл, чирэгдлийг бууруулна                                               |
|                                                      | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх                                                                            | Тийм |      | Тусламж, үйлчилгээний шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холботойгоор тус төвийн ажилтнууд гадаад улс, оронд төдийгүй өөрийн эх орондоо мэргэжил дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.               |

|                                       |                                                                                                                                                             |  |      |                         |
|---------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|------|-------------------------|
|                                       | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх |  | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй |
|                                       | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх                                                                                  |  | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй |
|                                       | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх                                                                                    |  | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх                                                                                      |  |      | хамааралгүй             |
|                                       | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх                                                                                                             |  |      | хамааралгүй             |
|                                       | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх                                                                                                             |  |      | хамааралгүй             |
|                                       | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх                                                                                         |  |      | хамааралгүй             |
| 8.Соёл                                | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх                                                                                                             |  |      | хамааралгүй             |
|                                       | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх                                                                    |  |      | хамааралгүй             |

|  |                                                             |  |  |             |
|--|-------------------------------------------------------------|--|--|-------------|
|  | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх |  |  | хамааралгүй |
|--|-------------------------------------------------------------|--|--|-------------|

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

| Үзүүлэх үр нөлөө                | Холбогдох асуулт                                                        | Хариулт |      | Тайлбар                                                                                                                             |
|---------------------------------|-------------------------------------------------------------------------|---------|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.Агаар                         | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх |         | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй. Барилгын бүтэц нь эко байдлаар зохион байгуулагдсан тул ижил барилгатай харьцуулахад байгалд ээлтэй байна. |
| 2.Зам тээвэр, түлш, эрчим хүч   | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх    |         | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                             |
|                                 | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх                             | Тийм    |      | Шинэ технологи нэвтрүүлэн орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдахад эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх боломжтой               |
|                                 | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх                         |         | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                             |
|                                 | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх              |         | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                             |
| 3.Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх                                |         |      | хамааралгүй                                                                                                                         |

|                    |                                                                             |      |      |                                                                                                                         |
|--------------------|-----------------------------------------------------------------------------|------|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                    | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх        |      |      | хамааралгүй                                                                                                             |
|                    | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх                      |      |      | хамааралгүй                                                                                                             |
|                    | 3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх                 |      |      | хамааралгүй                                                                                                             |
| 4.Усны нөөц        | 4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                 |
|                    | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх                                         |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                 |
|                    | 4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх                                         |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                 |
| 5.Хөрсний бохирдол | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх                                  |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                 |
|                    | 5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх             |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                                                                 |
| 6.Газрын ашиглалт  | 6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх                                | Тийм |      |                                                                                                                         |
|                    | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх                                         |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй. Улсын гуравдугаар төв эмнэлгийн эзэмшлийн ашиглагдаагүй газарт барилгыг барихаар төлөвлөгдсөн. |

|                                                         |                                                                                                                     |      |      |                                                                                   |
|---------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|-----------------------------------------------------------------------------------|
|                                                         | 6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх                                            |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                           |
| 7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | Тийм |      | Барига нь эко бүтэцтэй байж эргэн сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлсэн. |
|                                                         | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх                                                   |      | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй                                                           |

## ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### **7.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл (Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ)-ийн 6 дахь хэсэгт “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Хүний хөгжил, Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэгт “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “2.2.13. Оношилгоо эмчилгээний орчин үеийн дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдож эмчлэгдэх боломжийг бүрдүүлэх”, 2.2.15. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулах (Зүрх судасны төв...) гэж заасан.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт “Зүрх судасны төв байгуулах” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3 Эрүүл Монгол хүн хэсгийн 2.3.1.1 ... зарим тусламж үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулах /Зүрх судасны үндэсний төв/ гэсэн зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний Хүний хөгжлийн бодлого бүрэлдэхүүн хэсгийн 2.1.1.3-т “Зүрх судасны үндэсний төв байгуулах” гэж тусгасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлан гаргаж Монгол Улс нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах эрхтэй” гэж заасан.

Иймд дээрх хувилбар нь Монгол Улсын Үнсэн хууль болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцтой нийцэж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, хууль тэгшээр үйлчлэх зарчимд бүрэн нийцэж байгаа болно.

## **7.2. Хувилбарын сонголтын талаар**

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр Захиргааны шийдвэр гаргах, Хуулийн төсөл боловсруулах гэсэн хувилбаруудыг дэвшүүлж, хувилбаруудын зорилгод хүрэх байдал, эерэг сөрөг талуудыг харьцуулан судалж, Хуулийн төсөл боловсруулах гэсэн хувилбарыг оновчтой хувилбар хэмээн сонгов.

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын Хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөг шалгуур үзүүлэлтийн дагуу тандан судлахад хулийн төсөлтэй хамаарах үзүүлэлтүүд “эерэг” байна.

“ЗҮРХ СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,  
ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ  
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ”

## **ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН

**“ЗҮРХ СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК  
ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСӨЛ ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН  
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилт нь Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийн хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийв.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /Цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс доорх 4 шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Зардал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах үндэслэл шаардлагад нийцсэн эсэх, эсэхийг үнэлэх зорилгоор уг шалгуур үзүүлэлтийг сонгон авав.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийнэ.

**“Зардал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Зүрх судасны үндэсний төв байгуулахтай холбоотой гарах зардлын тооцоолол, Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцоог үнэлэхээр сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлэв.

## ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй учир үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоохдоо сонгосон 4 шалгуур үзүүлэлт тус бүрээр үр нөлөөг тогтоох судалгаа хийсэн.

## ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул энэ үе шатанд тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг доорх хүснэгтэд үзүүлж байна. Үүнд:

| №  | Шалгуур үзүүлэлт      | Үр нөлөөг үнэлэх хэсэг                                                                            | Тохирох шалгах хэрэгсэл                                                                                                                                                                                                                                                                      |
|----|-----------------------|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Зорилгод хүрэх байдал | Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.                                                                    | Зорилго, зорилтод хүрэхэд чиглэгдсэн хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх:                                                                                                                                                                                                               |
| 2. | Ойлгомжтой байдал     | Хуулийн төсөл бүхэлдээ                                                                            | Ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, тус хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. |
| 3  | Зардал                | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тооцоо хийх | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлын тооцоо хийх /аргачлалын дагуу тусдаа/                                                                                                                                                                               |
| 3. | Харилцан уялдаа       | Хуулийн төсөл бүхэлдээ                                                                            | Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10 дахь заалтын холбогдох хэсэгтэй нийцэж байгаа эсэхийг хянах                                                                                                                                                      |

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлж байна:

**1. Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Манай улсын хүн амын дунд Зүрх судасны тогтолцооны өвчин сүүлийн 30 жилийн хугацаанд нас баралтын тэргүүлэх шалтгаан, өвчлөлийн 3 дахь шалтгаан болсоор байна. Энэхүү өвчний улмаас жил бүр 5500-6000 хүн нас барж байгаагийн 62.2 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна<sup>1</sup>. Түүнчлэн зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 36.3 хувь нь 45-65 насны буюу ид хөдөлмөрийн насны иргэд байгаа нь онцгойлон анхаарах хэрэгтэйг илтгэж байна.

Сүүлийн 4 жилийн хугацаанд зүрх судасны эмгэгийн шалтгаант нас баралт 10000 хүн амд 2 промилээр бууруулсан ололттой тал байгаа хэдий ч иргэдийн дунд зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалт өндөр (хүн амын 30.8 хувь нь зүрх судасны өвчнөөр өвдөх 4-5 төрлийн эрсдэлтэй) байна<sup>2</sup>.

Үндэсний статистикийн хорооноос тооцоолон гаргасан 2050 он хүртэлх хүн амын нас хүйсийн суваргаар цаашид “насжилт” нэмэгдэж байгаа нь энэхүү өвчнөөр өвдөх эрсдэлт хүн ам улам бүр нэмэгдэх хандлагыг харуулж байна. Мөн 2017 онд хийгдсэн “Зүрх судасны үндэсний төв” байгуулах хэрэгцээ, шаардлагын судалгаагаар (Drees and Sommer 2017) зүрх судасны тусламж үйлчилгээ авах хэрэгцээ 2030 он гэхэд дунджаар 2.6 дахин нэмэгдэх тооцоолол гарсан байна.

Мөн судалгаагаар үндэсний түвшинд зүрх судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг давамгайлан үзүүлж байгаа Улсын Гуравдугаар төв эмнэлгийн ачаалал тухайлбал, зүрх судасны мэс заслын тусламж үйлчилгээ 1.9 дахин, зүрх судсан дотуурх мэс засал 1.5 дахин, ахисан түвшний зүрх судасны оношилгоо эмчилгээ 2.7 дахин нэмэгдэхээр дүр зураг тодорхойлогдсон байна. Сүүлийн жилүүдэд тус эмнэлэгт стандартын өндөр шаардлага бүхий ахисан түвшний мэс засал тухайлбал, хүүхдийн хүнд хэлбэрийн хавсарсан гажгийн мэс засал, судсан дотуур зүрхний хавхалга суулгах мэс засал гэх мэт оношилгоо эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрч байгаа цаашид улам өргөжүүлэх хэрэгцээ шаардлагын Зүрх судасны үндэсний төвийг төрөлжүүлэн байгуулах хэрэгцээ шаардлага бий болж байна

Зүрх судасны үндэсний төв байгуулагдсанаар тусламж үйлчилгээ үзүүлэх зай талбайн хүртээмж нэмэгдэх тухайлбал, мэс заслын өрөө 2 дахин, зүрхний судсан дотуурх мэс заслын өрөө 2 дахин, үзлэгийн өрөө 3 дахин, оношилгооны өрөө 3 дахин нэмэгдэж бие даасан яаралтай тусламж, ахисан түвшний дүрс оношилгоо, өдрийн эмчилгээ, ба зүрх судасны сэргээн засах эмчилгээний хэсэгтэй болно. Өөрөөр хэлбэл тусламж үйлчилгээний хүрээмжтэй байдлыг нэмэгдүүлнэ. Иргэд, эмчлүүлэгчид ба эмнэлгийн хог хаягдлын урсгал 100 хувь

<sup>1</sup> Эрүүл мэндийн үзүүлэлт 2024. ЭМХТөв

<sup>2</sup> Халдварт бүс өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний IV судалгаа 2019. Эрүүл мэндийн яам; Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

тусгаарлагдахаар зураг боловсруулагдсан нь ялангуяа халдварын эрсдэл, тусламж үйлчилгээг эрс бууруулах юм.

Цаг бусын нас баралт олон хөдөлмөрийн чадвар алдагдсан жилүүдийг нийтэд нь Эрүүл амьдралын алдагдсан жил (Disability adjusted life year - DALY) гэсэн үзүүлэлтээр өвчлөлийн эрүүл мэндийн үр нөлөөг дүгнэдэг. Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөндлөнгийн шинжээчдийн гаргасан судалгаанаас харахад Зүрх судасны үндэсний төвийн барилгыг барьж хүчин чадлыг нэмэгдүүлснээр 2030-2045 онд ойролцоогоор 12,246 Эрүүл амьдралын алдагдсан жилийг урьдчилан сэргийлэх боломжтой болох юм. Энэ нь жилд дундаар 627 эрүүл амьдралын алдагдсан жил ба 84 нас баралтыг сэргийлэх улмаар 57,059,684 ам долларыг хэмнэх боломжийг эрүүл мэндийн салбарт олгох юм. Мөн тус барилга нь ялгаруулах нүүрс хүчлийн хий, усны хэрэглээний хувьд хэмнэлттэй байх бөгөөд эдгээр нь жилд 171,327 ам долларын хэмнэлтийг гаргах боломжийг олгоно.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний дотоод урсгал, халдвар хамгааллын аюулгүй байдлыг бүрэн хангасан, эмчлүүлэгчдэд тав тухтай, аюулгүй, эрсдэлгүй орчинд тусламж үйлчилгээ авах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүд эрсдэлгүйгээр таатай, орчин үеийн стандартад нийцсэн орчинд тусламж үйлчилгээг үзүүлэх боломж бүрдэх болно. Хүний нөөц болон эмчлүүлэгчийн орны тоог эрс нэмэгдүүлэхгүйгээр, мөн лаборатори, дүрс оношилгооны хэсэг, хоол, ариутгал зэрэг бүтцийг давхардуулан байгуулахгүйгээр эмнэлгийн үндсэн тусламж үйлчилгээний цар хүрээг өргөтгөх боломжтой болох юм.

Дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд хуулийн төсөл зорилгоо илэрхийлсэн хэмээн үнэллээ.

## **2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Хуулийн төслийн зохицуулалт нь найруулга, хэлзүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд дор дурдсанаар нарийвчлан үнэлж байна:

| <b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>                                                                  |                                                            |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------|
| <b>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</b>                                                                                                                                           | <b>Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал</b> |
| 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх | Шаардлага хангасан.                                        |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                     |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх                                                                                                                                                                                                                                                   | Шаардлага хангасан. |
| 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх                                                                                                                                                                                                                                               | Шаардлага хангасан. |
| 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх                                                                                                                                                                                     | Шаардлага хангасан. |
| 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх                                                                                                                                                                                                                                                                                        | Шаардлага хангасан. |
| 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх                                                                                                                                                                                                                                           | Шаардлага хангасан. |
| 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх                                                                                                                         | Шаардлага хангасан. |
| 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.                                 | Шаардлага хангасан. |
| 29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана. | Шаардлага хангасан. |
| 29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.                                                                                                                                                                                          | Шаардлага хангасан. |
| 29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.                                                                                                                                                                                                  | Шаардлага хангасан. |
| <b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>                                                                                                                                                                                                                    |                     |
| 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх                                                                                                                                                                                                                                                               | Шаардлага хангасан. |
| 30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх                                                                                                                                                                                                                                                                               | Шаардлага хангасан. |

|                                                                                                                   |                     |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих | Шаардлага хангасан. |
| 30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх                                                                   | Шаардлага хангасан. |
| 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх                                                                     | Шаардлага хангасан. |

### 3. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг хавсаргав

### 4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу хуулийн төслийн уялдаа холбоог холбогдох асуултад хариул өгөх замаар шалгав.

|                                                                                                                    |                                                                                                          |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|
| Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх                                            | Тийм                                                                                                     |
| Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх       | Тийм                                                                                                     |
| Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцсэн. |
| Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх                   | Тийм                                                                                                     |
| Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх                    | Үгүй                                                                                                     |
| Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх                                                       | Тийм                                                                                                     |
| Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх                                                        | Үгүй                                                                                                     |
| Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх                                | Үгүй                                                                                                     |
| Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх          | Үгүй                                                                                                     |
| Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх                                 | Үгүй                                                                                                     |

|                                                                                                                                                   |                                                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх | Тийм                                                            |
| Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх                        | Үгүй                                                            |
| Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх                                                                              | Тийм                                                            |
| Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх                                                               | Үгүй                                                            |
| Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх                                                                   | Үгүй                                                            |
| Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх                               | Тус хуулийн төслөөр зохицуулагдах харилцаанд хамааралгүй байна. |

## ТАВ. ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ

### 5.1. ҮР ДҮН

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шат нь үр дүнг баримтжуулах, үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн дарааллаар явагдана.

1. Үр дүнг баримтжуулах: Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг үндэслэсэн.

2. Үнэлэх: Хуулийн төслийн үр нөлөөг хэрхэн үнэлснийг шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргаж байна.

**Зорилгод хүрэх байдал:** Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хуулийн төслийн зохицуулалттай харьцуулан судалсан бөгөөд хуулийн төслийн зохицуулалт нь үндэслэл, шаардлагыг хангаж байна гэж үзсэн.

**Ойлгомжтой байдал:** Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд тус тус нарийвчлан үнэлснээс хуульд заасан шаардлага хангасан гэж үзсэн.

**Зардал:** Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг тусад нь хавсаргав

**Харилцан уялдаа:** Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалд заасан асуултуудад хариулах байдлаар шалган уялдаа холбоог хангасан гэж үзсэн.

## **5.2 ЗӨВЛӨМЖ**

Энэхүү үнэлгээг “Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу тооцож дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Энэхүү үнэлгээг эдгээр хуулийн төсөлд хийхэд сонгосон шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

---oOo---

“ЗҮРХ СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,  
ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ  
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ”

## **ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН

## **ҮНДЭСЛЭЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

### **ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд иргэнд шууд үүрэг бий болгосон зүйл, заалт агуулаагүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

### **ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Төслийн нийт төсөвт өртөг 62,189,000.00 ам.доллар бөгөөд нийт санхүүжилтийн 42.33 хувь буюу 22,500,000.00 евро (~26,325,000.00 ам.доллар)-г Люксембургийн Засгийн газрын буцалтгүй тусламж, 1.6 хувь буюу 850,000.00 евро (~994,500.00 ам.доллар)-г Европын сэргээн босголт, хөгжлийн банкны буцалтгүй тусламж, 56.07 хувь буюу 34,870,000.00 ам долларыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.

Улсын гуравдугаар төв эмнэлэг нь “Хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн дагуу үүсэх нэмэлт зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх санхүүгийн боломж бүрдээгүй байна. Иймд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн дагуу үүсэх нэмэлт зардлын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд Монгол Улсын 2026, 2027, 2028, 2029, 2030, 2031, 2032 оны Төсвийн тухай хуульд тус тус өргөн мэдүүлж шийдвэрлэхээр төлөвлөж байна.

### **ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ТӨРД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд төслийн үндсэн хөрөнгө оруулалтыг урт хугацаат

зээлийн хөрөнгөөр, урсгал зардлыг зээлийн хөрөнгөөр бус Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр Сангийн яам, Эрүүл мэндийн яам, хөрөнгө оруулагч Люксембургийн Засгийн газар ба Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран шийдвэрлэсэн болно.

— oOo —

## АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД

| № | Нэр           | Албан тушаал                                                                                                          | Байгууллага                   | Гар утас |
|---|---------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|----------|
| 1 | Б.Жавхлан     | Сангийн сайд                                                                                                          | Сангийн яам                   | -        |
| 2 | Ж.Чинбүрэн    | Эрүүл мэндийн сайд                                                                                                    | Эрүүл мэндийн яам             | -        |
| 3 | С.Тулга       | Санхүүгийн бодлогын газрын дарга                                                                                      | Сангийн яам                   | 98110000 |
| 4 | Л.Гантогтох   | Өрийн удирдлагын хэлтсийн дарга                                                                                       | Сангийн яам                   | 99160950 |
| 5 | Н.Хүрэлбаатар | Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга                                                                             | Эрүүл мэндийн яам             | 99003867 |
| 6 | Ц.Төмөр-Очир  | Улсын гуравдугаар төв эмнэлгийн Ерөнхий захирал                                                                       | Улсын гуравдугаар төв эмнэлэг | 99037227 |
| 7 | Д.Мөнгөнчимэг | Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны зөвлөх, Люксембургийн хөгжлийн агентлагийн Салбар хариуцсан ахлах зөвлөх | Улсын гуравдугаар төв эмнэлэг | 99098912 |